

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 1

Японы барилгын ажлын гүйцэтгэлийн тогтолцоонд мэргэжлийн ажил гүйцэтгэгчийн талаар тайлбарласан бичвэр дараахаас аль нь вэ?

1. Барилгын ажлыг барилгын компаниар захиалж хийлгэнэ.
2. Захиалагчийн шаардлагыг биелүүлэх үүднээс зураг төсөл боловсруулна.
3. Томоохон барилгын талбайн үйл ажиллагааг бүхэлд нь хянаж, удирдан чиглүүлнэ.
4. Ажил тус бүрийн мэргэжилтэн буюу даамлын зааврын дагуу хэд хэдэн ажилтан ажлыг гүйцэтгэнэ.

Хариулт : 4

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 2

1, 2, 3 гэсэн ур чадварын түвшин тогтоож, үүнийг улсаас баталдаг тогтолцоо буюу ур чадварын түвшин тогтоох шалгалт байдаг. Ур чадварын шалгалтад тэнцсэн хүнийг юу гэж дуудаж болох вэ?

1. Ур чадвартай мэргэжилтэн
2. Техникч
3. Өмгөөлөгч
4. Хуулийн мэргэжилтэн

Хариулт: 1

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 3

Ажлын байран дахь ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, мөн тав тухтай ажиллах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд аль нь тохирохгүй вэ?

1. Эрсдэлийн үнэлгээ
2. Эрх мэдлийн дарамт
3. КҮ үйл ажиллагаа
4. Стресс шалгах

Хариулт : 2

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 4

Барилгын үйл ажиллагааны тухай хуулиар барилгын ажлыг хэвийн явуулах нөхцөлийг хангах үүднээс заавал байх ёстой инженер, техникийн ажилтныг сонгоно уу.

1. Хяналтын инженер /Ерөнхий инженер
2. Талбайн орлогч
3. Аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцагч
4. Даамал

Хариулт: 1

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 5

Нисэхийн тухай хуулиар бүртгэл хийлгэх ёстой зүйл нь дараахаас аль нь вэ?

1. Дамжуулагч
2. Шилэн кабелийн холбоо
3. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)
4. Газар доорх автомашины зогсоолын байгууламж

Хариулт : 3

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 6

Далай тэнгисийн барилгын ажилд усан дор ажиллаж чадах хүнийг юу гэдэг вэ?

1. Хийн гагнуурчин
2. Тэсэлгээний техникч
3. Даралт тохируулах ажилтан
4. Усанд шумбагч

Хариулт : 4

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 7

Гадасны барилгын ажилд, үйлдвэрт үйлдвэрлэсэн гадсыг зөөвөрлөж, суулгах барилгын аргыг юу гэдэг вэ?

1. Өрөмдлөг
2. Хайгуул
3. Бэлдмэл гадасны барилгын арга
4. Талбай дээр цутгах бетон гадас

Хариулт : 3

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 8

Барилгын чичиргээг хянах үүднээс барилгад сааруулагч гэх мэт энерги шингээх механизмуудыг суурилуулах ажлыг юу гэдэг вэ?

1. Чичиргээ хянах барилгын ажил
2. Газар хөдлөлтөд тэсвэртэй барилгын ажил
3. Газар хөдлөлтөөс хамгаалах барилга байгууламж
4. Хүчитгэх ажил

Хариулт: 1

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 9

Дараах өгүүлбэрийн ()-д орох үгийг сонгоно уу.

Цахилгаан харилцаа холбооны барилгын ажилд голчлон утас болон () гэх мэт мэдээлэл дамжуулан, хэрэглэхэд зориулсан сүлжээг бий болгодог.

1. Дэд станцын байгууламж
2. Розетка
3. Цэнэглэгч
4. Интернет

Хариулт : 4

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 10

Температур, чийгшлийг тохируулж, тав тухтай амьдрах нөхцөлийг хангах үүднээс агаар цэвэршүүлдэг төхөөрөмж суурилуулах ажлыг сонгоно уу.

1. Цэвэр бохир усны барилгын ажил
2. Хөргөгч, агааржуулалтын тоног төхөөрөмжийн барилгын ажил
3. Дулаан /хүйтэн тусгаарлагч барилгын ажил
4. Гал унтраах тоног төхөөрөмжийн барилгын ажил

Хариулт : 2

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 11

Газар ухаж, газар доорх болон суурийн ажил дууссаны дараа барилга байгууламж болон түүний эргэн тойронд үүссэн сул оройн зайг шороогоор булах ажлыг юу гэдэг вэ?

1. Буцааж дүүргэх ажил
2. Тэгшлэх ажил
3. Хөрс овоолох, дүүргэх ажил
4. Ухах ажил

Хариулт: 1

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 12

Далайн ёроолын газар шорооны барилгын ажил гэж ямар ажлыг хэлэх вэ?

1. Элс шороо цуглуулж, далайд шинэ газар байгуулах ажил
2. Далайн болон гол мөрний ёроолын элс шороог зайлуулах ажил
3. Боомт дээр усан онгоцонд ачаа ачих, буулгахад зориулсан усан онгоцны зогсоол байгуулах ажил
4. Боомт руу давалгаа орохоос хамгаалах байгууламж барих ажил

Хариулт : 2

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 13

Арматур болон арматурын холбох хэсгийг халааж, тэнхлэгийн чиглэлд даралтаар холбох аргыг юу гэдэг вэ?

1. Хийн даралтат гагнуурын холбоос
2. Гагнуурын холбоос
3. Механик холбоос
4. Давхарлах холбоос

Хариулт: 1

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 14

Цахилгаан тоног төхөөрөмжийн барилгын ажилд хамаарахгүй зүйлийг сонгоно уу.

1. Хуваарилах самбар суурилуулах барилгын ажил
2. Цахилгаанд цохиулах, цахилгааны алдагдлаас сэргийлэх болон газардуулгын барилгын ажил
3. Шилэн кабелин холболтын ажил
4. Халаалтын болон хөргөлтийн төхөөрөмжийн цахилгаан хангамжийг нийлүүлэх ажил

Хариулт: 3

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 15

Усны хоолойноос түгээх хоолойг дамжуулан усыг ариун цэврийн өрөө, гал тогоо зэрэгт нийлүүлэх насос болон усны танкыг суурилуулах, сантехникийн ажлыг юу гэдэг вэ?

1. Ус хангамжийн тоног төхөөрөмжийн барилгын ажил
2. Хийн тоног төхөөрөмжийн барилгын ажил
3. Дулаан /хүйтэн тусгаарлагч барилгын ажил
4. Цахилгаан харилцаа холбооны барилгын ажил

Хариулт: 1

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 16

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн дагуу тусгай сургалтад хамрагдах шаардлагатай ажлыг сонгоно уу.

1. Хэвний тулгуур угсрах ажил
2. Шатамхай хий, хүчилтөрөгч ашигласан металл гагнуурын ажил
3. Бетон бутлуур ашиглан бутлах ажил
4. Хамгийн их даац нь 1 тн-оос бага сэрээт өргөгч төхөөрөмжийн дүүжлүүрийн ажил

Хариулт : 4

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 17

Өөрөө төдийгүй бусдад осол, гэмтэл бэртэлгүй тухайн өдрийн ажлаа саадгүй явуулаасай гэж ерөөх үеийн мэндчилгээг сонгоно уу.

1. Аюулгүй байгаарай
2. Өглөөний мэнд
3. Уучлаарай
4. Аюултай

Хариулт: 1

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 18

Налуу болон тэгш бус газар, нам дор газрыг элс шороо овоолж, тэгш гадаргуутай болгох ажлыг сонгоно уу.

1. Хөрсний зүсэлт
2. Хөрс овоолох, дүүргэх
3. Замын суурь
4. Тулгуур хана

Хариулт : 2

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт
(Онолын шалгалт)

Асуулт 19

Арматурын барилгын ажилд арматурыг байрлуулж, угсрахыг юу гэдэг вэ?

1. Чангалах
2. Хуваарилах
3. Арматур өрөх
4. Цутгах

Хариулт: 3

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт
(Онолын шалгалт)

Асуулт 20

Цахилгаан гүйж буй хэсгээс бусад хэсэг рүү гүйхгүй болгохыг юу гэдэг вэ?

1. Булах
2. Утас сүвэгчлэх
3. Нуух
4. Таслах

Хариулт : 4

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 21

Барилгын талбайд тохирох хувцаслалт /үйлдлийг сонгоно уу.

1. Урт ханцуй, урт өмд
2. Ханцуйгаа шамлах
3. Гараа халаасандаа хийж алхах
4. Хүрэмний товчийг тайлж задгайлан өмсөх

Хариулт: 1

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 22

Даамлын ажил үүрэгт тохирох зүйл дараахаас аль нь вэ?

1. Ажилчдад зохих заавар өгч, зорилгоо биелүүлэхийн тулд ажлыг явуулах.
2. Ажилчдын цалинг тооцоолох.
3. Дунд болон түүнээс том хэмжээний барилгын талбайд талбайн даамал болж ажлыг удирдах.
4. Зураг төсөл боловсруулах.

Хариулт: 1

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 23

Барилгын талбайн аюулгүй байдлын менежментэд шаардагдах хамгийн тохиромжтой ур чадварыг сонгоно уу.

1. Ажлыг чанартай гүйцэтгэх ур чадвар
2. Зардлын ухамсар
3. Аюултай болон хортой шинж байдлыг таних чадвар
4. Графикийн хоцрогдлыг нөхөж зохицуулах чадвар

Хариулт: 3

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 24

Бэлтгэл 8, ажил 2 гэсэн утга санаанд хамгийн тохиромжтой нэг тайлбарыг сонгоно уу.

1. Бэлтгэлийг 8 минутад дуусгах
2. Ажил эхлэхийн өмнө бэлтгэх нь чухал
3. Ажилд бэлтгэл шаардлагагүй
4. Ажлын чанар нь бэлтгэл шатаас хамаарахгүй

Хариулт : 2

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 25

Барилгын ажил дээр ажлын өртгийн "хөдөлмөрийн хөлсний зардал"-ын талаар дурдсан бичвэр нь дараахаас аль нь вэ?

1. Барилгын ажлыг гүйцэтгэх ажилчдын хөлс
2. Барилга угсралтад шаардлагатай эд зүйлсийг худалдан авах зардал
3. Үйл явцын нэг хэсгийг туслан гүйцэтгэгч зэрэгт захиалах зардал
4. Ажлын машин худалдаж авах зардал

Хариулт: 1

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 26

Барилгын ажилд шаардлагатай хугацааг тогтоох аргуудаас, ажлыг хугацаанд нь амжуулахын тулд дуусах өдрөөс ухрааж график гаргах аргыг юу гэдэг вэ?

1. Урагш тооцох арга
2. Ухрааж тооцох арга
3. Бууруулах арга
4. Зайлсхийх арга

Хариулт : 2

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 27

Чанарын хяналтын талаар тохирох нэг бичвэрийг сонгоно уу.

1. Зураг төслийн агуулгын талаар захиалагч нь архитектораас тайлбар авна.
2. Ашиглалтад орсны дараа далдлагдах хэсгүүдийн гүйцэтгэлийн үеийн зургийг авах шаардлагагүй.
3. Ажилчдад арга техникийг тайлбарлахгүйгээр, дагалдуулж сургана.
4. Дефект гарсан үед талбай дээрх бодит байдлыг харахаас илүүтэй, туршлагаараа шийднэ.

Хариулт: 1

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 28

Аюулгүй байдал болон эрүүл ахуй хариуцсан ажилтнуудыг удирдан чиглүүлж, ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтыг явуулдаг албан тушаалтныг юу гэж нэрлэдэг вэ?

1. Архитектор
2. Даамал
3. Талбайн даамал
4. Аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий менежер

Хариулт : 4

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 29

Ажлын горимыг ойлгоход хялбар байдлаар боловсруулах гол түлхүүрийн хувьд тохирохгүй зүйлийг сонгоно уу.

1. Хялбар үйлдлүүдийг товчлох
2. Товч бөгөөд нуршихгүй бичих
3. Болзошгүй эрсдэлийг анхааруулга хэлбэрээр бичих
4. Үйлдлийг хийх ёстой шалтгааныг бичих

Хариулт: 1

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 30

Эрсдэлийн үнэлгээг хэрэгжүүлэх үр дүнгийн талаар дараахаас тохирохгүй зүйл аль нь вэ?

1. Эрсдэлийн талаарх ойлголтоо нэгтгэж чадна.
2. Аюулгүйн арга хэмжээг оновчтой аргаар эрэмбэлж чадна.
3. Ажилчид аюулгүй байдлын талаар бодолгүй, ажилдаа төвлөрч чадна.
4. Ажлын байран дахь бүх ажилчдын "аюулгүй байдал"-ын талаарх мэдрэмжийг нэмэгдүүлж чадна.

Хариулт : 3

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 31

Эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаар авч үзэх үед үндсэн арга хэмжээнд тохирох зүйлийг сонгоно уу.

1. Хортой материалыг аюулгүй материалаар солих
2. Хамгаалалтын бээлий хэрэглэх
3. Ажлын гарын авлагыг боловсруулах
4. Хамгаалалтын хашаа суурилуулах

Хариулт: 1

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 32

Хүний алдааны 12 төрлийн шалтгаанд хамаарахгүй зүйлийг сонгоно уу.

1. Ядрах
2. Товчлох үйлдэл
3. Олуулаа шалгах
4. Холбоо харилцаа дутах

Хариулт: 3

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 33

Стандарт нормд бичигдэх агуулгад хамаарахгүй зүйл аль нь вэ?

1. Материал
2. Тоног хэрэгсэл
3. Барилгын арга
4. Хөдөлмөрийн нэгж үнэ

Хариулт : 4

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Онолын шалгалт)

Асуулт 34

Барилгын салбарын үүргийн талаар тохирох бичвэрийг сонгоно уу.

1. Гамшигт өртсөн барилга байгууламжийг засах
2. Олон давхар орон сууцыг борлуулах
3. Цэвэр, бохир усны шугамаар хангах
4. Зам тээврийн үйл ажиллагаа эрхлэх

Хариулт: 1